

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

2026 оны 06 дугаар сарын 23

Улаанбаатар хот

“Улсын бүртгэлийн ерөнхий газрын
2026 оны эхний хагас жилийн
үйл ажиллагааны тайлан”

1. Улсын бүртгэлийн байгууллагын үүсэл хөгжил

1940 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 67 тогтоолоор “Иргэний паспортын дүрэм”-ийг баталсан. Улсын цагдан сэргийлэх газрын харьяанд “Паспортын хэлтэс”-ийг байгуулан өөр улсын бүртгэлийн суурь тавигдаж улмаар 2009 онд Улсын бүртгэлийн байгууллага нэгдсэн тогтолцоонд шилжиж, Улсын бүртгэлийн ерөнхий газар байгуулагдсан.

АЛСЫН ХАРАА-VISION

Иргэн, хуулийн этгээдийн хэрэгцээ шаардлагыг хангасан иргэн төвтэй, тэгш хүртээмжтэй төрийн цахим үйлчилгээг өргөжүүлнэ.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Олон улсын жишигт нийцсэн улсын бүртгэлийн тогтолцоог хөгжүүлнэ.

2. Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр

Улсын бүртгэлийн байгууллага нь Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргийн хүрээнд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн хүрээнд 2026 оны эхний хагас жилийн байдлаар дараах арга хэмжээг хэрэгжүүллээ.

Улсын бүртгэлийн ерөнхий газар нь нийслэлийн 9 дүүрэг, нэг цэгийн үйлчилгээний нэгдсэн 28 төв, цэг, 21 аймаг, 352 сум тосгон, 51 Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн болон хуулийн этгээдэд улсын бүртгэлийн үйлчилгээг холбогдох хууль тогтоомжийн дагуу иргэдэд хүргэн улсын хэмжээнд 2026 оны эхний хагас жилийн байдлаар иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 295,539, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 228,492, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 29686 нийт 553,717 улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн.

Мөн E-Mongolia, E-Business төрийн үйлчилгээний нэгдсэн системээр иргэний бүртгэлийн чиглэлээр 3,758,764, эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр 479,154, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 69,255, улсын бүртгэлийн үйлчилгээний 106 ширхэг

цахим машинаар (Киоск) 126,755 үйлчилгээ, 63,295 лавлагаа, лавлагаа үйлчилгээг тус тус үзүүлсэн байна.

Төрийн үйлчилгээг тэгш хүртээмжтэйгээр хүргэх зорилгоор бүртгэлийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдийн байгаа байршилд нь очин бүртгэлийн үйлчилгээг биеэр болон цахим хэлбэрээр авах боломжгүй зорилтот бүлгийн иргэн (өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, бичиг баримтгүй гэх мэт иргэд), алслагдсан газарт оршин суугч, хүнд өвчтэй иргэд, цэргийн анги, эмнэлэг, асрамжийн газар, хорих байгууллага, боомт, нүүрс тээврийн жолооч, нэг дор олноороо ажилладаг ажиллагсадтай томоохон аж ахуйн нэгжүүдэд улсын бүртгэлийн зөөврийн буюу хөдөлгөөнт үйлчилгээг 486 иргэнд үзүүллээ.

3.Удирдлага зохион байгуулалтын хүрээнд

Байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 36 арга хэмжээг төлөвлөн хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулан хэрэгжилтийг ханган, эхний хагас жилийн байдлаар 91.5 хувьтай байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/45 дугаар тушаалаар улсын бүртгэлийн байгууллагын бүтэц зохион байгуулалтыг дахин шинэчлэн баталснаар Төрийн албаны зөвлөлийн тогтоолоор шинээр 4, нэмэлт өөрчлөлт 15 албан тушаалын тодорхойлолтод зөвшөөрөл аван баталлаа. Мөн кибер аюулгүй байдлыг хангах, халдлагаас урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан чиг үүрэг бүхий Кибер, аюулгүй байдлын хэлтсийг шинээр байгуулан ажиллаж байна.

Байгууллагын 1067 төрийн захиргааны албан хаагчид хамаарах 73 албан тушаалын тодорхойлолт, төрийн үйлчилгээний 196 албан хаагчид хамаарах 27 ажлын байрны тодорхойлолтыг батлан, мөрдөн ажиллаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газар нь зохион байгуулалтын бүтцийн 7 газар, 34 хэлтэстэй бөгөөд Улсын бүртгэлийн ерөнхий газар 146, дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс 418, орон нутгийн Улсын бүртгэлийн хэлтэс 699 нийт 1263 албан хаагчийн орон тоотой. Гэвч байгууллагын үндсэн үйл ажиллагааны хэвийн байдлыг хангах туслах чиг үүргийг 2017 оноос эхэлж гэрээт ажилтнаар гүйцэтгүүлж ирсэн ба одоогоор байгууллагын хэмжээнд 76, үүнээс нийслэлд 21 гэрээт ажилтан ажиллаж байна.

Үүнээс удирдах албан тушаалтан 42, гүйцэтгэх албан тушаалтан 1025, туслах чиг үүргийн 196 албан хаагчидтайгаас тэргүүн түшмэл 1, эрхэлсэн түшмэл 7, ахлах түшмэл 34, дэс түшмэл 1025 байна.

Албан хаагчдын 18-29 насны 125, 30-40 насны 526, 41-55 насны 578, 56- аас дээш 34, эмэгтэй 957, эрэгтэй 306, эрх зүйч мэргэжилтэй 661, нягтлан бодогч мэргэжилтэй 178, багш мэргэжилтэй 172, инженер мэргэжилтэй 91, төрийн удирдлага мэргэжилтэй 47, бизнесийн удирдлага мэргэжилтэй 38 байна.

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн байруудад дохиолол, хамгаалалтын систем хуваарийн дагуу бүрэн суурилуулагдаж дууссан. Нийт 12 аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн байрыг гал, усны, хөдөлгөөний мэдрэгч бүхий дохиолол

хамгаалалтын системээр иж бүрэн тоноглох ажлыг 07 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн 09 дүгээр сарын 03-ны хүртэлх хугацаанд амжилттай гүйцэтгэн, Засгийн газрын “цахимжуулалтыг эрчимжүүлэх, хүний оролцоотой үйл ажиллагааг багасгах” бодлогыг хэрэгжүүлж, нийт 36 харуул, манаачийн гэрээт орон тоог хэмнэсэн.

4.Хүний нөөц, сургалтын чиглэлээр

“Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын дагуу 2026 оны нэгдүгээр улирлын байдлаар төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх зарыг 6 удаа, удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг 5 удаа тус тус зохион байгуулж, нийт 38 орон тоог нөхөн бүрдүүлсэн байна. Үүнээс удирдах албан тушаал 5, гүйцэтгэх албан тушаал 33 орон тоо тус тус нөхөгдсөн.

Хүний нөөцийн оновчтой бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд нийт 32 албан хаагчийн мэдлэг, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажилласан жилийг харгалзан үзэж төрийн захиргааны албан тушаалын ТЗ-7 ангиллаас ТЗ-6 ангилалд дэвшүүлэн томилсон.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны “Хөтөлбөр батлах тухай” А/206, байгууллагын даргын 2024 оны А/180 дугаар “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийг баталж дунд хугацаанд хэрэгжилтийг хангахаар ажиллаж байна.

Байгууллагын даргын 2026 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн А/94 дүгээр тушаалаар “Улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах сургалтын хөтөлбөр (2026-2029)”-ийг баталж, үүнтэй уялдуулан байгууллагын албан хаагч, ажилчдыг сургах 2026 оны төлөвлөгөөг 3 зорилт, 56 арга хэмжээтэй батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд Удирдах албан тушаалтны цугларалт, сургалтыг 2026 оны 03 дугаар сарын 12-ноос 14-ний өдрүүдэд зохион байгуулж 45 удирдах албан тушаалтан, 01 дүгээр сарын 14-ний өдрөөс 16-ны өдрийн хооронд 9 дүүрэг, 21 аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн нийт 26 захиргааны ахлах мэргэжилтэн нарт захиргааны ахлах мэргэжилтэн нарыг чадавхжуулах сургалтыг тус тус зохион байгуулсан. Мөн шинээр томилогдсон албан хаагчдын чиглүүлэх сургалтыг 03 дугаар сарын 02-ны өдрөөс 10-ны өдрийн хооронд зохион байгуулж 25 шинээр томилогдсон албан хаагчийг хамруулсан бөгөөд байгууллагын дотоод нөөц бололцоог ашиглан танхимын 6 удаагийн сургалтад 145 албан хаагч, бусад байгууллагатай хамтран танхим, цахим хосолсон 26 удаагийн сургалтад давхардсан тоогоор 1370 албан хаагчийг хамруулсан.

“Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын дагуу 2026 оны нэгдүгээр улирлын байдлаар төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх зарыг 6 удаа, удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг 5 удаа тус тус зохион байгуулж, нийт 38 орон тоог нөхөн бүрдүүлсэн байна. Үүнээс удирдах албан тушаал 5, гүйцэтгэх албан тушаал 33 орон тоо тус тус нөхөгдсөн.

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн сумын улсын бүртгэгчийн 28, дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн улсын бүртгэгчийн 9, нийт 37 сул орон тоог нөхөхөөр төлөвлөж, Төрийн албаны зөвлөлд 2026 оны 1/3371, 1/2640 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн. Үүнээс төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журмын дагуу сумын улсын бүртгэгчийн 4, дүүргийн улсын бүртгэгчийн 3, нийт 7 сул орон тоог нөхсөн. Мөн 2025 оны 05 дугаар сарын 05, 06, 25, 26-ны өдрүүдэд зохион байгуулагдсан хоёр удаагийн тусгай шалгалтын үр дүнд аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн сумын улсын бүртгэгчийн 17, дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн улсын бүртгэгчийн 6 орон тоог тус тус нөхөн томилсон.

Улсын бүртгэлийн байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын 7.1 дэх хэсэгт “ажлын өдрийн үргэлжлэл 8 хүртэл цаг байна”, “төв байгууллагын ажлын цагийн горимыг дулааны ба хүйтний улирлын онцлогийг харгалзан байгууллагын даргын тушаалаар тухай бүр баталж болно” гэж тус тус гэж заасан. Хэрэгжилтийн хүрээнд байгууллагын даргын 2025 оны А/95 дугаар тушаалаар төв байгууллагын албан хаагчдын ажил эхлэх цагийг 08:00, тарах цагийг 17:00, 0-11 насны хүүхэдтэй албан хаагчдын ажил эхлэх цагийг 08:30, тарах цагийг 16:30 байхаар, мөн 2026 оны А/40 дүгээр тушаалаар хөгжлийн бэрхшээлтэй албан хаагч болон хөгжлийн бэрхшээлтэй, асаргаа шаардлагатай хүүхэдтэй албан хаагчдын ажлын цагийг 7 хоногт 36 цаг байхаар тус тус зохицуулсан.

5. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр

Улсын бүртгэлийн байгууллагын 2025-2028 онд хэрэгжүүлэх “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийн хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газрын архивын зориулалттай барилга байгууламж болон албан хаагчдын орон сууцны барилга, угсралтын ажлыг гүйцэтгэх гэрээг 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр “Буянт шарга констракшн”-тай байгуулсан. Албан хаагчдын орон сууцны барилга нь 16 давхар 4 блок бөгөөд хөнгөлөлттэй орон сууцанд орох 241 өргөдөл хүсэлтээс 125 албан хаагч квотод хамрагдсан. Арилжааны 8 банктай уулзалт ярилцлагыг товлож, албан хаагчдад банкны зээлээр орон сууц олгох боломж нөхцөлийг ярилцаж, Голомт банкиг сонгон 1.3 хувийн хүүтэй банкны орон сууцны зээлийг олгуулахаар тохиролцсон. Барилгын гүйцэтгэл 70 хувьтай.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025-2028 онд хэрэгжүүлэх “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 зорилт 10 арга хэмжээтэйгээр батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд:

-33 албан хаагчид шинээр, 86 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулан олгож нийт 119 албан хаагчийн зэрэг дэвийн нэмэгдлийг шинэчлэн олгосон;

-Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу байгууллагын даргын тушаалаар 18 албан хаагчид 9,016,700 төгрөгийн тусламж, 29 албан хаагчид сургалтын цалинтай чөлөө, байгууллагын даргын 2026 оны А/40 дүгээр тушаалаар хөгжлийн бэрхшээлтэй албан хаагчид болон хөгжлийн бэрхшээлтэй, асаргаа шаардлагатай хүүхэдтэй 37 албан хаагчийн ажиллах цагийг 1 цагаар богиносгосон;

-Аймаг, дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн 120 албан хаагч эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан;

-Хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Улсын бүртгэлийн ерөнхий газрын албан хаагчдын дунд 2026 оны 02 дугаар сард гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулж, 05 дугаар сараас эхлэн иогийн сургалтыг 7 хоногийн 3 өдөр зохион байгуулж байна;

-Албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулан Азийн хөгжлийн банкны санхүүжилт, бусад төрийн байгууллагын дэмжлэгтэйгээр Төв аймаг, Налайх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн байранд нийт 8,100,000 төгрөгийн төсвөөр засвар үйлчилгээ хийсэн;

-Аймаг, дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэст шаардлагатай техник, тоног төхөөрөмж болох зөөврийн компьютер 30, суурин компьютер 30, принтер 23, скайнер 12 хүлээлгэн өгсөн;

-Архангай, Дорнод, Завхан, Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст 4 автомашиныг тус тус хүлээлгэн өгсөн.

6.Төрийн үйлчилгээг илүү шуурхай, хүртээмжтэй хүргэх,
төр өөрт байгаа мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй
байх боломжийг нэмэгдүүлэх, улсын бүртгэлийн үйлчилгээг хялбаршуулах,
чирэгдэлгүй болгох зорилгоор

6.1.Тамга, тэмдгийн хяналтын дугаар олгох, захиалах үйлчилгээг И Монгол академи, 38 тамганы үйлдвэрүүдтэй хамтран 2026 оны 02 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн бүрэн цахимаар үзүүлж эхлэн 05 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар 6548 хяналтын дугаар олгосон байна.

6.2.2026 оны 02 дугаар сараас эхлэн хуулийн этгээдийн нэр баталгаажуулах үйлчилгээнд AI технологийг нэвтрүүлэн, шинээр байгуулсан компанийн баримт бичгийг цахимаар хүлээн авах маягыг шинэчилж тоон гарын үсгээр баталгааждаг болж 05 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар нэр өөрчилсөн 6, нэрийн баталгаажилтын хугацаа сунгасан 39, шинээр нэр авах хүсэлт 19828 тус тус хүлээн авч холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэсэн.

6.3.Иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх улсын бүртгэлийн үйлчилгээг хялбаршуулах зорилгоор улсын ерөнхий байцаагчийн 4 дүгнэлт, 4 тушаал гаргасан.

6.3.1.Улсын ерөнхий байцаагчийн 2026 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 1125 дугаар дүгнэлт гарган эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд бүртгэсэн мэдээлэл нь эх нотлох (архивын) баримтаас зөрүүтэй, алдаатай цахимжсан бол энэ дүгнэлтийг үндэслэн холбогдох эрхийн улсын бүртгэлд засвар, өөрчлөлт оруулах боломжтой болон, 314 бүртгэлийн засвар, өөрчлөлт оруулсан байна.

6.3.2. Улсын ерөнхий байцаагчийн 2026 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 1164 дугаар дүгнэлт гарган хаяж, үрэгдүүлсэн үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээг дахин авахад тухай бүр хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гарснаар улсын бүртгэл хөтлөх процесс нь ихээхэн хугацаа шаарддаг байсныг болиулан улсын ерөнхий байцаагчийн байнгын шинжтэй дүгнэлт гарган цаашид иргэн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг хүлээж хугацаа алдахгүй болж, 820 иргэнд гэрчилгээг дахин олгосон байна.

6.3.3. Улсын ерөнхий байцаагчийн 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 1352 дугаар дүгнэлт гарган (зөвхөн дахин төлөвлөлтөд орж газар чөлөөлөх арга хэмжээ авагдсан) үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх болон түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрх дуусгавар болсон тохиолдолд тус дүгнэлтийг үндэслэдэг болж эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд түргэн шуурхай хүргэх боломжийг бүрдүүлэн 713 бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн байна.

6.3.4. Нэгдсэн үйлчилгээний төв, цэгийн улсын ахлах бүртгэгчид 2026 оны А/55 дугаар тушаалаар тухайн асуудлыг хянан шийдвэрлэх, шаардлагатай дүгнэлтийг гаргах эрх олгосноор иргэн улсын бүртгэлийн үйлчилгээг нэг цэгээс илүү шуурхай авах боломж бүрдсэн. Тушаалын хэрэгжилтийн хүрээнд 05 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар 29 иргэний өргөдөл гомдлыг хүлээн авч хяналтын байцаагчийн дүгнэлт гаргасан байна.

6.3.5. Улсын ерөнхий байцаагчийн 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 1989 дугаар дүгнэлт гарган иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд 2012 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуусталх хугацаанд эх нотлох баримтаас зөрүүтэй, алдаатай бүртгэгдсэн зөрчлийг арилгаж, улсын бүртгэлийн мэдээллийн санг үнэн зөв бүрдүүлэх боломжийг бүрдүүлэн 737 бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн байна.

6.3.6. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2026 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/72 дугаар “Цахим мэдээллийн санд нэвтрэх эрх нээх тухай” тушаалаар улсын бүртгэлийн үйлчилгээний нээлттэй байдал, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, нийтийн мэдээлэл хариуцагч өөрт байгаа мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй байх хүрээнд иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд нэвтрэх эрх (хайлт хийх, харах) 246 улсын бүртгэгчид нээсэн.

6.3.7. Сумын улсын бүртгэгч нар нь эрх зүйч мэргэжилтэй, төрийн захиргааны албан хаагч байдаг учраас хялбаршуулсан журмаар зөрчил шийдвэрлэх эрхийг 133 улсын бүртгэгчид 2026 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/130 дугаар тушаалаар олгосон.

6.3.8. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/77 дугаар тушаалаар хөдөө, орон нутгийн алслагдсан 59 суманд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрхийг олгосон.

6.4. Барьцааны гэрээг цахим хэлбэрээр үйлдэх, баталгаажуулах (цаасаар үйлдээд скайнердах биш бүрэн цахим гэрээ байгуулах) дэвшилтэт арга хэлбэрийг судлан, барьцааны гэрээний эрхийн бүртгэлийг цахимжуулах туршилтыг 2026 оны 04 дүгээр сараас эхлүүлэн, 07 дугаар сараас туршилтаар нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Тус ажлын хүрээнд Засгийн газрын 2021 оны 226 дугаар тогтоолоор баталсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэвлэх журам”-д 2026 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 146 дугаар тогтоолоор холбогдох хэсэг, заалтад нэмэлт, өөрчлөлтийг оруулсан.

6.5. Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, түүнийг дагалдан гарах Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, танилцуулга, хуульд хийсэн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлангийн хамт Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2026 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 1/4327 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Улсын бүртгэлийн багц хуулийн нэмэлт, өөрчлөлт батлагдсанаар дараах эерэг үр дагаврууд гарна.

6.5.1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэсэн, орон зайнаас үл хамаарах үйлчилгээ нэмэгдэнэ.

6.5.2. Улсын бүртгэлийн үйлчилгээг хялбаршуулах, төр өөрт байгаа мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй байх, улсын бүртгэлийн гэрчилгээг цахимаар олгоно.

6.5.3. Улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх, авахад зарцуулах хугацаа богиносж, иргэд болон байгууллагын зардал хэмнэгдэнэ.

6.5.4. Хиймэл оюун ухаанд суурилсан технологийг бүртгэлийн үйл ажиллагаанд нэвтрүүлнэ.

6.6. Улсын бүртгэлийн байгууллагад хиймэл оюунд суурилсан технологи, программ хангамжийг нэвтрүүлэхээр ажиллаж байна. Үүнд:

6.6.1. Иргэний өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх программ хангамж;

6.6.2. Ухаалаг чатбот (мэдээллийн сан нь хуулиар нээлттэй байхаар тусгасан мэдээллийн иргэдэд хурдан шуурхай, цэгцтэй хүргэх программ хангамж);

6.6.3. Тайлангийн нэгдсэн программ хангамж;

6.6.4. Цахим гэрчилгээг олон хэлээр хөрвүүлэн авах боломжтой программ хангамж;

6.6.5. Цахимаар ирүүлсэн нотлох баримтыг шалгах программ хангамж;

6.6.6. Сонгогчийн ирц бүртгэлийн программ хангамж;

6.6.7. Иргэний бүртгэлийг системийг шинэчлэн хөгжүүлэх (Civil 4.0).

6.7. Улсын бүртгэлийн ерөнхий газрын нэгдсэн архив болон дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн архивт хадгалагдаж байгаа эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн баримтын бүрэн бүтэн, аюулгүй байдал, хадгалалт, хамгаалалт, баримтын бодит тоог тогтоох, дутагдсан баримтыг илрүүлэх, ангилан ялгалт хийх, ажлын байранд зураг авалт хийж, бүтэц, орон тоо, цалингийн сан болон зохион байгуулалтын арга хэмжээ авах үүрэг бүхий ажлын хэсгийг 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн

A/11 дугаар тушаалаар байгуулан байгууллагын хэмжээнд анх удаа тооллогыг зохион байгуулсан.

Тооллогын үр дүнд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 774,172 хувийн хэргийн 33,803,803 хуудас хувийн хэрэг, 8849 бүртгэлийн дэвтрийг тооллогод хамруулсан. Үүнээс мэдээлэл лавлагааны ач холбогдолгүй хадгалах шаардлагагүй гэж үзсэн 3,693,811 хуудас баримтыг ялгасан.

6.8.“Евразийн иргэний бүртгэгчдийн нийгэмлэг”-ийн 2026 оны уулзалтыг Үндэсний статистикийн хороотой хамтран 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс 04-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулсан. Уулзалтаар “Евразийн орнуудын иргэний бүртгэлийн системийн өнөөгийн нөхцөл байдал”, “Улс орнуудын системийг сайжруулах чиглэлээр хийж буй ажлууд, ойрын төлөвлөгөө болон дараагийн алхмууд”, “Иргэний бүртгэгчдэд зориулсан өгөгдөл хамгаалалт ба өгөгдлийн засаглал” сэдвүүдээр танилцуулга, хэлэлцүүлгийг хийсэн. Хөтөлбөрийн дагуу 06 дугаар сарын 03-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газарт “Евразийн иргэний бүртгэгчдийн нийгэмлэг”-ийн 29 зочид, төлөөлөгчдийг хүлээн авч, танилцах айлчлалыг зохион байгуулан Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаа, иргэний улсын бүртгэлийн чиглэлээр хийж хэрэгжүүлж байгаа ажлыг танилцуулсан.

6.9.“Эрдэнэс тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшигч нас барсан иргэний нэр дээр бүртгэлтэй хувьцааг өвлүүлэхтэй холбоотой, өв хүлээн авах ажиллагаанд шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх, мэдээлэл солилцоог шуурхай болгох, байгууллагуудын уялдаа холбоог хангах, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх нөхцөлийг хангах арга хэмжээний хүрээнд “ХУР” системд 3 шинэ сервис хөгжүүлэн нэвтрүүлсэн.

-WS102104_ETTMarriageInfo - ЭТТ хувьцааны өв залгамжлал гэрлэлт болон цуцлалт

-WS102105_WomanXAATR- Хүүхэд төрүүлсэн тухай маягтын мэдээлэл ХААТР-01

-WS102106_SPRMDecease -Нас баралтын мэдээлэл дамжуулах-ЭТТ, нотариат

Мөн Сүхбаатарын талбайд 2026 оны 5 дугаар сарын 30, 31-ний өдөр зохион байгуулсан нээлттэй мэдээлэл өгөх өдөрлөгт холбогдох албан хаагчид (зөөврийн тоног төхөөрөмж) оролцож 30-ний өдөр 50 иргэнд, 31-ний өдөр 68 иргэний мэдээлэл шалгаж, 105 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

Нийслэлд үйл ажиллагаа явуулдаг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын харьяа 7 НЦҮТөв, Дүүргийн Засаг даргын харьяа 9 НЦҮТөв, Улсын бүртгэлийн бие даасан 15 НЦҮТөв, нийт 31 НЦҮТөв дээр 2026 оны 06 дугаар сарын 02,03,04-ний өдрүүдэд "ЭТТ ХК-ийн хувьцаа, ногдол ашиг өвлүүлэх" арга хэмжээг зохион байгуулагдсан.

6.10.E-Business 2.0 системийн шинэчилсэн хувилбар нь хуулийн этгээдийг үүсгэн байгуулахтай холбоотой үйл ажиллагааг бүрэн цахим хэлбэрээр хэрэгжүүлэх боломж бүрдэж, иргэн, хуулийн этгээд төрийн байгууллагад биечлэн хандах шаардлага багасаж, цаг хугацаа болон зардлаа хэмнэх нөхцөл бүрдсэн. (2026.06.16)

Мөн цаасан суурьтай бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулснаар бичиг баримтын хэвлэл, хадгалалт, архивын зардал буурч, төрийн үйлчилгээний бүтээмж нэмэгдэх ач холбогдолтой юм. Түүнчлэн бүртгэлийн үйл ажиллагааны тодорхой үе шатууд цахимжсанаар улсын бүртгэгчийн гар ажиллагаа болон ажлын ачаалал буурч, үйлчилгээг илүү шуурхай, хүртээмжтэй хүргэх боломж бүрдсэн.

Шинэчилсэн хувилбараар:

- 1.Хуулийн этгээдийг нэрийг хиймэл оюун ухаанд (AI) суурилан шүүх
- 2.Хуулийн этгээдийн дансыг цахимаар нээх;
- 3.Хуулийн этгээдийн тамга, тэмдгийн дугаарыг цахимаар илгээх;
- 4.Хуулийн этгээдийг шинээр байгуулах баримт бичгийг олон улсын жишигт нийцүүлэн тоон гарын үсгээр баталгаажуулан цахимаар илгээх боломжийг тус тус бүрдүүлээ.

6.11.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд 16 аймгийн 42 сумын 71 хэсэгт зохион байгуулагдах нөхөн болон дахин сонгуулийн итгэмжлэгдсэн ажилтан нарт 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдөр эрх зүйн болон программын дадлага олгох сургалт зохион байгуулж, сонгуулийн хэсэг тус бүрт үүссэн лавлагааг сонгогчдын нэрийн жагсаалтад тусган, сонгогчдын нэрийн жагсаалтыг 2 хувь хэвлэж, сонгуулийн хэсгийн хороонд хүргүүлэх ажлыг зохион байгуулсан.

2026 оны 06 дугаар сарын 15-ны өдөр эцсийн байдлаар үндсэн сонгогч 46,967, хасагдсан 1788, нийт 48,755 сонгогчдын нэрийн жагсаалтыг хэвлэсэн.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/37 дугаар захирамжийн дагуу Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн болон дахин сонгуульд ашиглах сонгуулийн автоматжуулсан систем, түүний иж бүрдэл программ хангамж техникийн хэрэгслийг 16 аймгийн 42 сумын 71 хэсгийн санал авах байршилд турших үйл ажиллагааг 2026 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн Улаанбаатарын цагаар 12 цагт сонгуулийн бүх хэсэгт сонгогчдын ирцийн мэдээ дамжуулах туршилтын ажлыг амжилттай зохион байгууллаа.

Тагнуулын ерөнхий газар болон Сонгуулийн ерөнхий хорооны албан хаагчдын хяналттайгаар 71 хэсгийн компьютерт мэдээллийн санг хуулбарлаж, нөөц компьютерын хамт хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулсан.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд 16 аймгийн 42 сумын 71 хэсэгт зохион байгуулагдах нөхөн болон дахин сонгууль 2026 оны 06 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулагдан, үндсэн чиг үүргийн хүрээнд холбогдох арга хэмжээг зохион байгуулан ажилласан.

7.Мэдээллийн сан, программ хангаж

7.1.Манай байгууллага нь бүртгэлийн цахим үйлчилгээг өргөжүүлж, төрийн байгууллагууд болон иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор Монгол Улсын төрийн мэдээлэл солилцооны ХУР системд одоогийн байдлаар 384 төрлийн сервисийг дангаар нийлүүлж байна. Эдгээр сервисийг төр болон хувийн

хэвшлийн байгууллагууд улсын хэмжээнд мэдээлэл баталгаажуулах суурь өгөгдөл болгон тогтмол ашиглаж байна.

Улсын бүртгэлийн байгууллага 2022–2025 онд дээрх 385 сервисээс хамгийн их ашиглагддаг топ 10 сервисийн хандалтын тоо 1.3 тэрбумд хүрсэн нь бүртгэлийн цахим үйлчилгээний хэрэгцээ, ач холбогдол өндөр байгааг илтгэж байна.

Бүртгэлийн үйл ажиллагаанд одоогоор иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэл, бүртгэлийн нэгдсэн архивын нийт 4 үндсэн систем ашиглагдаж байна. Эдгээр системийг дэмжих зорилгоор нийт 91 программ хангамж ажиллаж байна.

Мэдээллийн сангийн хувьд 37 үндсэн мэдээллийн сан, 400 гаруй оффлайн дэд сан, мөн сонгуулийн үйл ажиллагаанд ашиглагддаг 2,100 файл хэлбэрийн сан бүртгэлтэй байна. Эдгээрт хадгалагдаж буй нийт өгөгдлийн хэмжээ ойролцоогоор 250ТВ-д хүрч байна.

Бүртгэлийн өгөгдлийн бүтцийн хувьд 3.6 сая иргэний бүртгэл, 1.4 сая эд хөрөнгийн бүртгэл, 272 мянган хуулийн этгээдийн бүртгэл, 53 мянган захиргааны болон процессын өгөгдөл, 3.8 сая биометр өгөгдөл (хурууны хээний темплейт), мөн 885 мянган РКI нийтийн түлхүүрийн өгөгдөл хадгалагдаж байна.

Эдгээр систем, өгөгдөл нь бүртгэлийн нэгдсэн сүлжээгээр дамжин нийт 498 нэгж байгууллагатай холбогдон ашиглагдаж байна.

Эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийн үйл ажиллагаанд иргэний мэдээллийг шалгахдаа иргэний бүртгэлийн системтэй холбогдон, иргэний хурууны хээ болон регистрийн дугаарыг ашиглан хайлт, баталгаажуулалт хийж байна. Бүртгэлийн системүүд нь төрийн дараах системүүдтэй шууд холбогдон ажиллаж байна. Үүнд:

- Төрийн мэдээлэл солилцооны ХУР системд 384 төрлийн сервисийг дангаар нийлүүлж байна.
- Танилт баталгаажилтын ДАН системтэй холбогдон ажиллаж байна.
- Сонгуулийн ерөнхий хороотой хамтран сонгогчийн нэрийн жагсаалтыг үйлддэг.
- Хил хамгаалах ерөнхий газар гадаад паспортын идэвхитэй хатуу дугаарын мэдээллийг байнга шинэчлэн авдаг.
- Тагнуулын ерөнхий газар, Авилгатай тэмцэх газар иргэний бүртгэлийн системд шууд нэвтрэн орж ашиглах эрхтэйгээр ажиллаж байна.
- “Төрийн үнэт цаас хэвлэл” ТӨДХХК шууд холбогдон өдөрт 1800-2000 гаран гадаад паспортын захиалсан иргэдийн мэдээллийг татан авч хэвлэлт хийж байна.

7.2. Улсын бүртгэлийн байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлж болох нийт 151 төрлийн лавлагаа, үйлчилгээ нь бүрэн цахимжиж, E-Business, E-Mongolia системд амжилттай нэвтрүүлж дууссан.

Иргэний улсын бүртгэлийн нийт 44 лавлагаа, үйлчилгээ.

- Үйлчилгээ-27
- Лавлагаа-17

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн нийт 42 лавлагаа, үйлчилгээ.

- Үйлчилгээ-40
- Лавлагаа-2

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн нийт 65 лавлагаа, үйлчилгээ.

- Үйлчилгээ-43
- Лавлагаа-22

7.3.Улсын бүртгэлийн ерөнхий газрын баталсан удирдамжийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.22 дахь хэсэгт заасны дагуу гадаад улсад амьдарч байгаа иргэдийн Монгол Улсын Үндсэн хуульд заасан сонгуульд оролцох эрхийг хангах, санал өгөх боломжийг бүрдүүлэх, иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, төрийн үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай хүргэх зорилгоор иргэний улсын бүртгэлийн оффлайн системийг нууцлал бүхий сүлжээ /VPN/-д холбох, иргэний улсын бүртгэлийн ажилтны улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд дэмжин туслах, чадавхжуулах, иргэний улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаатай танилцах, хянах, бүртгэл хариуцсан ажилтныг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, мэдээлэл солилцох болон гадаад улсад байгаа Монгол Улсын иргэдэд улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх зорилгоор хилийн чанадад ажиллаж байгаа ДТГ-т VPN сүлжээ тавих шийдлийг гаргаж, холбогдох лиценз, программ хангамжийг бэлэн болгосон. Тагнуулын байгууллагын зөвлөмж чиглэлийг дор хилийн чанадад ажиллаж байгаа нийт 50 ДТГ-ын бүртгэлийн ажилтны тоног төхөөрөмжийг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд холбогдсон.

8.Улсын бүртгэлийн байгууллага дараах үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

8.1.Улсын бүртгэлийн тогтолцоог сайжруулах, иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх улсын бүртгэлийн үйлчилгээний чанарыг олон улсын жишигт үе шаттайгаар хүргэх.

8.2.Хүний нөөцийн удирдлагын шилдэг арга барилыг хэрэглэх, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах замаар оновчтой, чадварлаг бүтцийг бий болгох.

8.3.Олон улсын болон гадаад орны ижил төстэй байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх, иргэд харилцан зорчих нөхцөлийн талаарх олон улсын болон хоёр талт гэрээний хэрэгжилтийг хангах.

8.4.Шинэ дэвшилтэд технологид суурилсан буюу цаг хугацаа, орон зайнаас үл хамааран хийгдэх улсын бүртгэлийн үйлчилгээний тоог нэмэгдүүлэх.

8.5.Улсын бүртгэлийн нэгдсэн сангийн нууцлал, аюулгүй байдлыг ханган, кибер халдлагаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх.

9.Төсөв, санхүүжилтийн талаар

Улсын бүртгэлийн ерөнхий газар нь 2025–2026 оны төсвийн гүйцэтгэлд дараах санхүүгийн хүндрэлтэй тулгарч байгаа бөгөөд тэдгээрийг нэн даруй шийдвэрлэхгүйгээр байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байдал, иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанарт ноцтой нөлөөлөх эрсдэл тулгарч байна. Нийт

шаардлагатай санхүүжилтийн хэмжээ болон үүний нарийвчилсан тайлбарыг дараах байдлаар тодорхойлж байна.

9.1.2025 оны төсвийн санхүүжилт бүрэн шийдвэрлэгдээгүйгээс иргэний үнэмлэхийн бэлдцийн зардалд 1,619,594,800 төгрөг, гадаад паспортын бэлдцийн зардалд 3,358,665,000 төгрөг, нийт 4,978,259,800 төгрөгийн өр төлбөр тайлант жилд шилжин үлдсэн. Уг өр төлбөрийг Засгийн газрын нөөц сангаас шийдвэрлүүлэх хүсэлтийг Сангийн яаманд хүргүүлсэн боловч Сангийн яамнаас 2026 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн №01/2156 дугаар албан бичгээр “батлагдсан төсөвт зохицуулалт хийх замаар шийдвэрлэх” чиглэл ирүүлсэн боловч 2026 оны байгууллагын дотоод нөөцөөс тус дүнг шийдвэрлэх боломж байхгүй байна.

Нийлүүлэгч тал төлбөр барагдуулаагүй тохиолдолд бэлдэц нийлүүлэлтийг зогсоох эрхтэй бөгөөд 2026 оны хоёрдугаар хагасаас эхлэн иргэний үнэмлэх болон гадаад паспорт олгох үйл ажиллагаа бүрэн зогсох бодит эрсдэл тулгарч байна. 2027 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн өмнөх бэлтгэлийн үед иргэний бичиг баримтын эрэлт огцом нэмэгдэх тул нөөцгүй байх нь төрийн үйлчилгээг тасалдуулах нөхцөл үүсгэнэ.

9.2.2026 оны цалингийн сангийн дутагдал Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 226 дугаар тогтоолоор төрийн захиргааны албан хаагчдын цалинг шинэчлэн тогтоосны дагуу албан хаагчдын цалинг тооцоолон олгож байгаа бөгөөд дараах дүнгийн дутагдал үүсэхээр байна.

-Цалингийн санд: 3,645,948,000 төгрөг дутагдал;

-Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд: 469,047,570 төгрөг дутагдал;

-Нийт дутагдал: 4,114,995,570 төгрөг.

9.3.Тоон гарын үсгийн лицензийн төлбөр: “Тридум Кэй” ХХК-тай байгуулсан гэрээний хүрээнд 2023–2024 онд хамаарах 88,850.00 евро тэглэгдэж, 2025–2026 оны нийт дүнгээс 144,006.80 евро (~614 сая төгрөг)-ийн хөнгөлөлт авснаар 2025–2026 оны нийт лицензийн төлбөрийг 1,209,000,000 төгрөгөөр тогтоон гэрээ байгуулсан. Гэвч 2026 оны батлагдсан төсөвт уг зардал тусгагдаагүй тул өр төлбөр үүсч байна. Лицензийн төлбөр хийгдэхгүй тохиолдолд улс орны хэмжээнд тоон гарын үсэг ашиглах боломжгүй болж, цахим орчин дахь хуулийн хэрэгжилт тасалдах эрсдэл бий болж байна.

9.4.Урсгал зардлын хязгаарлагдмал санхүүжилт: 21 аймаг, 330 суманд үйл ажиллагаа явуулдаг байгууллагын 2026 оны батлагдсан нийт төсвийн 96 хүртэлх хувийг зөвхөн цалингийн сан эзэлж байна. Үлдэх 10 хүрэхгүй хувь нь тогтмол зардал болон урсгал зардалд хуваарилагдсан тул нэгжүүдийн өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах боломжгүй байна. Тулгарч буй гол хүндрэлүүд:

-Баянхонгор, Завхан аймагт тээвэр, шатахууны зардал огт батлагдаагүй; зарим нэгжийн сарын шатахуун 15,000–100,000 төгрөг буюу 25–150 км замд л хүрэхүйц хэмжээнд байна;

-Нийслэлийн Хан-Уул, Сүхбаатар, Баянзүрх дүүрэг болон Дорноговь, Дундговь аймгийн нэгжүүдийн байрны батлагдсан түрээсийн зардал хүрэлцээгүй байна;

-21 аймгийн нийт урсгал засварын батлагдсан төсөв 2,316,500 төгрөг бөгөөд энэ нь барилгын дотно засвар, хаалга, цонхны засвар хийх боломжгүй. Иргэдэд үйлчилгээ үзүүлдэг байрны орчны чанар тасралтгүй доройтсоор байна;

-Хөрөнгө оруулалтын тусгай төсөв байхгүйгээс тавилга, компьютер, тоног төхөөрөмж хуучирч элэгдэн, засвар үйлчилгээ авахааргүй болсон нь албан хаагчдын ажлын цагийг уртасгах, иргэдийн оочир дараалал нэмэгдэх зэрэг асуудлуудтай тулгарч байна.


9.5.Тэтгэвэр, тэтгэмж, урамшуулалын дутагдал: 2026 онд 30 ажилтны тэтгэвэр болон 5 ажилтны архивчийн урамшуулал, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны дэмжлэг зэрэг нийт 1,977,171,500 төгрөгийн тэтгэмжийн санал хүргүүлснийг зөвхөн 60 хувиар нь батлагдсан тул үлдэх 40 хувь буюу 790,868,600 төгрөгийн дутагдал үүсч байна. Энэ нь Хөдөлмөрийн дотоод журамд тусгасан нийгмийн баталгааны хэрэгжилтийг хангахгүй байгаагаас албан хаагчдын сэтгэл ханамж буурах, хөдөлмөрийн харилцааны зөрчил үүсэх нөхцөл бий болж байна.

9.6.Шаардлагатай нийт санхүүжилтийн нэгтгэл: Дээр дурдсан санхүүгийн тулгамдаж буй асуудлуудыг нэгтгэвэл нийт 11,852,710,950 төгрөг (~12.0 тэрбум төгрөг) 2026 оны төсөвт шаардлагатай байна.

№	Зардлын нэр, үндэслэл	Шаардагдах дүн /төгрөг/	Тайлбар
1	2025 оны үлдэгдэл өр төлбөр (иргэний үнэмлэх, гадаад паспортын бэлдэц)	4,978,259,800	Нөөц сангаас шийдэх боломжгүй
2	2026 оны цалингийн сангийн дутагдал (195 ТҮ/ТҮМ, ЗГ-ын 226 тогтоол хэрэгжүүлэх)	4,114,995,570	Цалин + НДШ дутагдал
3	Тоон гарын үсгийн лицензийн төлбөр (2025–2026, Тридум Кэй ХХК)	1,209,000,000	Батлагдсан төсөвт тусгагдаагүй
4	Тээвэр, шатахуун, багаж, урсгал засвар	500,000,000	Батлагдсан төсөвт тусгагдаагүй
5	Тэтгэвэр, тэтгэмж, урамшуулалын дутагдал (нийт саналын 40%)	790,868,600	Батлагдсан төсөв хүрэлцээгүй
НИЙТ ДҮН		11,593,123,970	11.6 тэрбум төгрөг

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын
2026 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн
1/1508 дугаар албан бичгийн хоёрдугаар хавсралт



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2026 оны 06 дугаар сарын 12

Улаанбаатар хот

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
<p>ЗОРИЛГО.УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ИРГЭНИЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛЖ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ. /“Алсын хараа-2050” зорилт 5.3, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.3, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.1, Улсын бүртгэлийн байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө/ ЗОРИЛТ 1. ДЭВШИЛТЭД ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА БАЙНА.</p>							
1.1.	Иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх.	-	Иргэн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн иргэдийн тоо	1,206,015	2,000,000	Хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргийн хүрээнд нийслэлийн 9 дүүрэг, нэг цэгийн үйлчилгээний нэгдсэн 28 төв, цэг, 21 аймаг, 352 сум тосгон, 51 Монгол Улсаас хилийн чандад суугаа Дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан иргэн, хуулийн этгээдэд 2026 оны эхний хагас жилд нийт 553,717 үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнээс - Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 295,539, - Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 228,492, - Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 29,686 улсын бүртгэлийн үйлчилгээг тус тус үзүүлэв.	100

1.2.	Бүртгэлийн байгууллагын архивын цогцолбор төвийг ашиглалтад оруулах.	-	Ажлын чанар, гүйцэтгэлийн хувь	10	70	100
------	--	---	--------------------------------	----	----	-----

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны "Хөтөлбөр батлах тухай" А/206, байгууллагын даргын 2024 оны А/180 дугаар "Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр батлах тухай", 2025 оны А/96, А/97 дугаар "Ажлын хэсэг байгуулах тухай" тушаалын хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд УБЕГ-ын архивын зориулалттай барилга байгууламж болон албан хаагчдын орон сууцны барилга, угсралтын ажлыг гүйцэтгэх гэрээг 2025.05.30-ны өдөр "Буянт Шарга констракшн"-тай байгуулан, барилгын шав тавих ёслолыг 2025.06.05-ны өдөр зохион байгуулсан. Архивын зориулалттай барилга нь 1,500 м.кв талбайтай, хоёр давхар (зоорины давхартай) байхаар төлөвлөгдөж, барилгын нийт өртөг 6 тэрбум төгрөгийг гүйцэтгэгч "Буянт Шарга Констракшн" ХХК 100 хувь өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэн барилгын ажлыг гүйцэтгэж байна. Өвлийн ажлын хуваарьт шилжүүлэн, цутгалтын ажлыг түр зогсоосон байсан бөгөөд барилга угсралтын ажил 2026.02.21-ний өдрөөс эхлүүлээд байна. Тайлант хугацаанд албан хаагчдын орон сууцны I, II блокийн 16 давхрын цутгалт бүрэн хийгдэж дууссан. Мөн ажилчдын орон сууц, архивын барилга, орон сууцны нэгдсэн гражны "Ажлын зураг төсөв"-ийг Барилгын хөгжлийн төвөөр хянуулж дүгнэлт гаргуулан, хөндлөнгийн экспертүүд газар дээр нь ажиллаж, ажлын гүйцэтгэл 70 хувьтай, 12 тэрбум төгрөгийн үнэлгээтэй гэж дүгнэв.

1.3.	Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг цахим хэлбэрээр олгох ажлыг үе шаттайгаар эхлүүлэх.	-	Цахим хэлбэрээр олгосон улсын бүртгэлийн гэрчилгээний тоо	-	20	<p>Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн цахим гэрчилгээ олгох зохицуулалтыг боловсруулан, хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2026.06.03-ны өдрийн 1/4327 дугаар албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Мөн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн шинэ системд улсын бүртгэлийн гэрчилгээг цахим болон цаасан хэлбэрээр олгох боломжтой байхаар хөгжүүлэлт хийгдэж байна.</p>	30
1.4.	Нотариатчаас мэдүүлэг, холбогдох баримт бичгийг улсын бүртгэлийн мэдээллийн санд илгээх, бүртгүүлэх зуучлалын системээр үзүүлэх үйлчилгээний тоог нэмэгдүүлэх.	-	Нотариатчаар зуучлуулан бүртгэсэн бүртгэлийн тоо	340	500	<p>Нотариатчаас мэдүүлэг, холбогдох баримт бичгийг улсын бүртгэлийн мэдээллийн санд илгээх, бүртгүүлэх зуучлалын системээр үзүүлэх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээний тоог нэмэгдүүлэх ажлын хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2026.02.24-ний өдрийн А/41 тоот тушаалаар Монголын Нотариатчидын танхимтай хамтарсан Ажлын хэсгийг байгуулан Улсын бүртгэл, нотариатын гэрчлэлтэй холбоотой ойлголтын зөрүүтэй байдлыг арилгах, улсын бүртгэлийн үйлчилгээнд нотариатын зуучлалыг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.</p> <p>Улсын бүртгэлийн ерөнхий газар, Монголын нотариатчидын танхим, нотариатчийн зуучлалын цахим систем хөгжүүлэгч Интерактив ХХК-ийн төлөөллүүдийг оролцуулан хамтарсан уулзалт зохион байгуулав.</p> <p>Уулзалтаар нотариатчийн цахим системд гарч буй алдаа, зөрчлийг шалган туршилт хийж, санал солилцсон</p>	100

						<p>бөгөөд цаашид авч хэрэгжүүлэх холбогдох арга хэмжээг авч хамтран ажиллах тухай Монголын нотариатчидын танхимд 2026 оны 1/2655 дугаартай албан бичиг хүргүүлсэн. Тайлант хугацаанд улсын хэмжээнд 738 эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг нотариатчаар зуучлуулан бүртгэсэн байна.</p> <p>Нийслэлийн Багануур, Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс болон Жуков, Академи, Төв шуудан цэгүүдэд 2026.01.02-2026.04.30-ны өдөр хүртэл нотариатын зуучлалаар бүртгэсэн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээнд дүн шинжилгээ хийхэд нийт бүртгэлийн 90 гаруй хувийг ажлын 8 цагт багтаан бүртгэж, бүртгэл хөтлөх хугацааг багасгасан үр дүнтэй байна.</p>	
1.5.	Төрийн болон хууль хяналтын байгууллагатай цахимаар мэдээлэл, лавлагаа, хуулбар олгох.	Улсын төсөв	Цахим албан бичгээр солилцох төрийн байгууллагын тоо	24	25	<p>Энэ оны 1 дүгээр сараас эхлэн прокурор, шүүхийн байгууллагуудтай цахимаар лавлагаа, мэдээлэл солилцож ажлыг эхлүүлж цахимаар мэдээлэл солилцох төрийн байгууллагын тоог 2 нэмэгдүүллээ. Төрийн болон хууль хяналтын 26 байгууллагад 364 албан бичгээр иргэний улсын бүртгэлийн 2,930 лавлагаа, 17 хуулбар, 14,567 мэдээлэл, 233 албан бичгээр хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 975 лавлагаа, 33,110 хуулбарыг цахимаар тус тус олгосон.</p>	100
1.6.	Байгууллагын архивын баримтыг цахимжуулах.	-	Цахимжуулсан баримтын тоо	126	500	<p>Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/100 дугаар тушаалаар батлагдсан "Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам"-д заасны дагуу Төрийн архивын https://cams.e-archives.gov.mn систем ашиглах хүсэлтийг Архивын ерөнхий газар</p>	100

						хүргүүлж, хандах эрх авч үйл ажиллагаанд нэвтрүүлэв. Тайлант хугацаанд 2009 оноос 2024 он хүртэлх байнга хадгалах 650 хадгаламжийн нэгжийн 162,500 хуудсыг цахим хэлбэрт шилжүүлээд байна.	
1.7.	Үндэсний гадаад паспортын үсгэн код шинэчилсэн Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах.	-	Хэвлэгдсэн гадаад паспортын тоо	-	150,000	Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ИКАО/-ын ДОС 9303 стандартад шаардлагын дагуу Засгийн газрын 2025.12.31-ний өдрийн "Үндэсний гадаад паспортын загвар, тодорхойлолт батлах тухай" 247 дугаар тогтоолоор 2022 оны 155 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулж, албан гадаад паспортын серийг (РО), үндэсний энгийн гадаад паспортын серийг (РР) гэж өөрчилсөн. РР серийн үсгэн код бүхий цахим гадаад паспортын бэлдцэд бичилт хийх ажлыг туршиж, хэвлэх үйл ажиллагааны бэлэн байдлыг ханган, 2 төрлийн хилийн шалган нэвтрүүлэх системд туршилт хийсэн. РР серийн үсгэн код бүхий цахим гадаад паспортын хэрэглээнд нэвтрүүлэхтэй холбогдуулан БНХАУ-д зорчих иргэд Элчин сайдын яамаар дамжуулан виз мэдүүлэх, мөн өмнө нь визгүй зорчдог байсан иргэдийн хувьд БНХАУ-ын иргэдтэй адил нөхцөл, шаардлага тавигдах шинэ нөхцөл байдал бий болсон тул ХЗДХЯ, ГХЯ, УБЕГ, ХХЕГ зэрэг байгууллагуудын хамтарсан уулзалт зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	30
1.8.	Иргэний үнэмлэхийн QR кодыг хэрэглээнд нэвтрүүлэх.	-	Нийтийн тээврийн үйлчилгээнд нэвтрүүлсэн эсэх	-	1	Иргэний үнэмлэхийн QR кодыг нийтийн тээврийн үйлчилгээнд нэвтрүүлэхээр Нийгмийн даатгалын ерөнхий газартай 2026.04.23, 2026.05.28-ны өдрүүдэд хамтарсан уулзалтыг зохион байгуулж, нийтийн тээврээр үнэ төлбөргүй зорчдог	90

						иргэдийн мэдээллийн жагсаалтад өндөр настны мэдээллийг нэмж, сервисийн хөгжүүлэлтийг бүрэн хийж дуусгасан. Сервисийн хяналтыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамд хүргүүлэн шалгуулж эх кодыг хүлээн авсан бөгөөд сервисийн оролт, гаралтын утгуудыг нэмэлтээр хөгжүүлэн ажил гүйцэтгэгч байгууллага болох "Ай Си Ти групп" ХК-д 2026.04.23-ны өдөр цахим шуудангаар хүргүүлж, системийн хөгжүүлэлтийг 06 дугаар сард дуусгахаар төлөвлөн ажиллаж байна.	
1.9.	"E-Mongolia" системээр иргэдэд гадаад хэлээр олгох лавлагааны төрлийг нэмэгдүүлэх.	-	Нэмэгдүүлсэн лавлагааны төрөл	4	16	Улсын бүртгэлийн байгууллагаас олгодог лавлагаа, тодорхойлолтыг олон улсын хэрэглээнд нийцүүлэн иргэдэд цахим хэлбэрээр хүргэх ажлын хүрээнд иргэний улсын бүртгэлийн 7, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 2, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 5 төрлийн лавлагаа, тодорхойлолтыг орчуулах ажлыг зохион байгуулсан. Гадаад харилцааны яамнаас 2026.04.03-ны өдрийн 03/1485 дугаартай албан бичигт Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн орчуулгад хяналт хийж, санал, зөвлөмжийн хамт Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газарт (Хувийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт) хүргүүлсэн бөгөөд герман хэлнээс бусад хэлээр хянагдсан орчуулгыг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем e-Mongolia дахь "Апостиль гэрчилгээ авах хүсэлт" үйлчилгээнд нэвтрүүлэн ашиглах талаар санал, зөвлөмжийг тусгасан байна. Ийнхүү улсын бүртгэлийн лавлагаа, тодорхойлолтыг олон улсын хэлээр цахим хэлбэрээр авах боломжийг бүрдүүлэх, орчуулгын чанар, агуулгын хяналтыг холбогдох байгууллагаар	75

						<p>гүйцэтгүүлж, үйлчилгээг нэвтрүүлэх бэлтгэл ажил хангагдаад байна.</p> <p>Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн платформ И-Монгол системээр 2025.09.21-2026.05.14-ний өдрийн хугацаанд 4 төрлийн нийт 384,626 лавлагаа, тодорхойлолтыг англи, франц, солонгос, орос, хятад хэлээр олгосон. Үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> - англи хэлээр 245,488; - франц хэлээр 3,123; - солонгос хэлээр 130,772; - орос хэлээр 1,426; - хятад хэлээр 3,817. 	
1.10.	Бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналтыг сайжруулах.	-	Хяналт тавьсан бүртгэлийн тоо	150,956	305,000	<p>Тайлант хугацаанд хяналт шалгалтаар нийт 126,136 бүртгэлд хяналт тавьсан байна. Үүнээс иргэний улсын бүртгэл 74,394, эд хөрөнгийн эрхийн бүртгэл 34,603, хуулийн этгээдийн улсын бүртгэл 7,053, архивын чиглэлээр 10,086 бүртгэлд тус тус хяналт тавьж, 5,208 зөрчил илрүүлэн, 2,198 зөрчлийг арилгахаар холбогдох арга хэмжээг авсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчиж бүртгэсэн 273 бүртгэлийг хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр хүчингүй болгож шийдвэрлэсэн; - Хууль хяналтын байгууллагад 6 бүртгэлийг шалгуулахаар шилжүүлсэн; - Аймаг, нийслэл, сум, дүүргийн Улсын ахлах байцаагч болон хяналтын улсын байцаагч нарын 30 удаагийн албан шаардлага, 7 удаагийн мэдэгдэх хуудсаар 1919 зөрчлийг аргилуулахаа холбогдох алба, хэлтсүүдэд хүргүүлэв. 	100

1.11.	Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн албан хэрэгцээнд автомашины дэмжлэг үзүүлэх.	Орон нутгийн төсөв	Автомашины тоо	1	2	Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2023 оны 128,5 сая төгрөгийн үнэ бүхий Ланд Круйзер Прада-150 автомашиныг 2026.04.23-ны өдөр хүлээн авсан. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоолын дагуу хөрөнгийг бүртгэлжүүлэх ажлыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.	100
ЗОРИЛТ 2.ОРЧИН ҮЕИЙН ШИНЭ ТЕХНИК, ТЕХНОЛОГИ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙГ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА НЭВТРҮҮЛЖ, ТӨРӨӨС ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮЗҮҮЛЭХ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ, ШУУРХАЙ БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛНЭ.							
2.1.	Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хиймэл оюуны технологийг нэвтрүүлэх.	Улсын төсөв	Ажлын даалгавар, хөтөлбөр боловсруулж батлан холбогдох байгууллагад хүргүүлсэн тоо	-	2	Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2026.01.13-ны өдрийн А/06 дугаар тушаалаар "Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хиймэл оюунд суурилсан технологийг нэвтрүүлэх хөтөлбөр"-ийг батлан, ЦХИХХЯ-нд 2026.01.14-ны өдрийн 1/580 дугаар албан бичгээр "Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хиймэл оюунд суурилсан технологи нэвтрүүлэх" ажлын даалгаврыг хавсарган албан бичгээр цахимаар зөвлөмж, дүгнэлт гаргуулах хүсэлт хүргүүлсэн. Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнөх зөвлөмж, дүгнэлтийг 2026.02.09-ний өдөр баталж, цахимаар ирүүлсэн.	100
			Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан тоо	-	1	Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2026.02.23-ны өдрийн А/39 дугаар "Үнэлгээний хороо байгуулах тухай" тушаалаар улсын бүртгэлийн хиймэл оюунд суурилсан мэдээлэл технологийн тоног төхөөрөмж худалдан авах техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, баримт бичиг боловсруулах, тендер хүлээн авах, хянан үзэх, үнэлэх, дүгнэлт гаргах үүрэг бүхий үнэлгээний хороог байгуулсан.	100

						<p>УБЕГ/20260102008 дугаартай “Улсын бүртгэлийн хиймэл оюунд суурилсан мэдээллийн технологийн тоног төхөөрөмж худалдан авах” тендерийн баримт бичгийг 2026.03.02-ны өдөр боловсруулж, батлан. Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn)-д байршуулж, тендерийн нээлтийг 2026.03.30-ны өдрийн 09 цаг 30 минутад зохион байгуулахаар нээлттэйгээр зарласан.</p> <p>Тендерт “Интерактив” ХХК, “Грандмакс” ХХК оролцож, үнэлгээний хорооны шийдвэрээр “Грандмакс” ХХК-ыг шалгаруулж, холбогдох хууль, журмын дагуу “Интерактив” ХХК болон “Грандмакс” ХХК-д 2026.04.02-ны өдөр мэдэгдэл хүргүүлэн ажиллав. Гранд макс ХХК-тай 2026.04.23-ны өдөр 2026/03, 2026/38 дугаартай гэрээ байгуулсан бөгөөд гэрээнд тоног төхөөрөмж нийлүүлж, зургаан төрлийн программ хангамжийг хөгжүүлэхээр тусгасан.</p>	
			Тоног төхөөрөмж суурилуулж, тохиргоо хийсэн тоо	-	6	<p>Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2026 оны А/98 дугаар тушаалаар хиймэл оюуны загвар ажиллуулах, өгөгдөл боловсруулахад ашиглах техник, тоног төхөөрөмжийг хүлээн авах, суурилуулах, тохируулах ажлын хэсгийг байгуулан, 2026.06.05-ны өдөр гүйцэтгэгч “Грандмакс” ХХК-ийн төлөөлөлтэй уулзаж, тоног төхөөрөмжийг хүлээн авах, суурилуулах, техникийн болон аюулгүй байдлын шаардлагыг хэрэгжүүлэх асуудлаар санал солилцон, цаашдын ажлын төлөвлөгөөг хэлэлцсэн.</p>	25
			Иргэний өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх	-	100	<p>“Грандмакс” ХХК хооронд 2026.04.23-ны өдөр гэрээ байгуулж, хиймэл оюунд суурилсан 6 төрлийн программ хангамж</p>	25

			программ хангамжийг хэрэглээнд нэвтрүүлсэн хувь			хөгжүүлэх ажлыг эхлүүлээд байна. Төслийн хүрээнд байгуулагдсан ажлын хэсэг болон гүйцэтгэгч байгууллагын технологийн баг хамтран иргэний улсын бүртгэлийн систем, иргэний өргөдөл, гомдол, санал хүсэлт хүлээн авч шийдвэрлэх систем, ухаалаг чатбот, нотлох баримт хүлээн авах систем, цахим гэрчилгээг олон улсын хэлээр хөрвүүлэх систем, тайлангийн системийн шаардлагын тодорхойлолтыг боловсруулж, программ хангамжийн архитектур, интеграцийн шийдэл, өгөгдлийн бүтэц, UX/UI дизайн болон техникийн шаардлагын баримт бичгийг боловсруулах ажлыг тус тус хийж гүйцэтгэв. Боловсруулсан шаардлагын тодорхойлолтыг байгууллагын Бодлогын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, өгсөн санал, зөвлөмжийн дагуу сайжруулан ухаалаг чатбот, иргэний өргөдөл, гомдол, санал хүсэлт хүлээн авч шийдвэрлэх систем болон цахим гэрчилгээг олон хэлээр хөрвүүлэх программ хангамжийн шаардлагын тодорхойлолтыг 2026.06.04-ний өдөр батлуулж, гүйцэтгэгч байгууллагад хүргүүлсэн. Ингэснээр төслийн дараагийн шат болох техникийн зураг төсөл боловсруулах болон программ хангамжийн хөгжүүлэлтийн ажлыг эхлүүлэх нөхцөл бүрдсэн.	
			Ухаалаг чатбот хэрэглээнд нэвтрүүлсэн хувь	-	100		
			Цахим гэрчилгээг олон улсын хэлээр хөрвүүлэх программ хангамжийг хэрэглээнд нэвтрүүлсэн хувь	-	100		
			Нотлох баримт шалгах программ хангамжийг хэрэглээнд нэвтрүүлсэн хувь	-	100		
			Тайлангийн программ хангамжийг хэрэглээнд нэвтрүүлсэн хувь	-	100		
			Сонгогчийн нэрийн жагсаалтыг үйлдэх программ хангамжийг шинэчлэх хувь	-	50		
2.2.	Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн системийг шинэчлэх, хэрэглээнд нэвтрүүлэх.	ADB төсөл	Иргэний улсын бүртгэлийн систем /civil/-ийг шинэчлэх хувь	-	60	Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2026 оны А/06 дугаар тушаалаар батлагдсан Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хиймэл оюунд суурилсан технологийг нэвтрүүлэх хөтөлбөр болон ажлын даалгаварт тус тус үндэслэн, 2026.05.06-ны өдрийн А/95 дугаар	20

					тушаалаар байгуулагдсан "Ажлын хэсэг"-ийн гишүүд гүйцэтгэгч байгууллагын технологийн багтай хамтран иргэний улсын бүртгэлийн системийг шинэчлэх ажлын бодлогын даалгавар, шаардлагын тодорхойлолтыг боловсруулж 2026.06.09-ний өдөр баталсан.	
		Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим систем /eRS/-ийг шинэчлэх хувь	82	100	Хуулийн этгээдийн болон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн системийг хөгжүүлэх, нэвтрүүлэх төслийн хэрэгжилтийн явцад ажлын цар хүрээ, шаардлагын өөрчлөлт, интеграцийн ажлын нэмэгдэл болон туршилт, хүлээн авах үйл ажиллагааны нөхцөлөөс шалтгаалан гэрээний дагуу гүйцэтгэх ажлыг бүрэн, чанарын шаардлагад нийцүүлэн дуусгах шаардлага үүссэн тул Улсын бүртгэлийн ерөнхий газар, "Аствишн" ХХК системийн нэмэлт гэрээг 2026.04.09-ний өдөр байгуулан ажиллаж байна. Системийн хөгжүүлэлтийн хүрээнд ерөнхий 57, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 65, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 86 шаардлага ажлын даалгаварт туссан. Дээрх ажлын хүрээнд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн системийн гүйцэтгэл болон ажлын даалгаврын хэрэгжилтэд хяналт тавих, техникийн шаардлага, нөхцөлд нийцүүлэх талаар зөвлөгөө, мэдээллээр тогтмол ханган, доголдлыг арилгуулах арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлэн хөгжүүлэлтийн ажил хийгдэж байна.	30
		Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим систем /ePRS/-ийг шинэчлэх хувь	82	100	Тайлант хугацаанд төслийн хүрээнд шаардлагатай интеграцийн үйлчилгээнүүдийг тодорхойлж, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар, Монголын ипотекийн	30

					<p>корпорац, Татварын ерөнхий газартай тус тус байгууллага хоорондын интеграцийн шийдлүүдийг шинэ системд нэвтрүүлэх асуудлаар хамтарсан уулзалтуудыг зохион байгуулсан. Системийн туршилт, хүлээн авах ажиллагааны бэлтгэл ажлын хүрээнд системийн бүх цэс, үйл ажиллагааг хамарсан дэлгэрэнгүй төстийн төлөвлөгөө боловсруулж, хэрэглэгчийн шаардлагын дагуу туршилтыг зохион байгуулан илэрсэн алдаа, зөрчил, сайжруулалтын саналыг нэгтгэн хөгжүүлэгч байгууллагад хүргүүлсэн.</p> <p>"Аствишн" ХХК-тай байгууллагын удирдлагын түвшинд 3 удаагийн уулзалт зохион байгуулж, 2 удаа албан бичиг хүргүүлэн хөгжүүлэлтийн явцыг түргэвчлэх чиглэлээр тогтмол хамтран ажиллаж байна. Мөн 7 хоног бүрийн Мягмар гарагт системийн хөгжүүлэлтийн явцтай танилцах уулзалт хийж хэвшсэн бөгөөд шийдвэрлэх шаардлагатай асуудлыг тухай бүр шийдвэрлэж байна. 2026.06.05-ны өдрөөс Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэст системийг тестлэх ажлыг эхлүүлэн ажиллаж байна.</p>	
		Хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалтыг AI ашиглан автоматжуулах, хэрэглээнд нэвтрүүлсэн хувь	-	100	<p>Хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалтын үйл ажиллагааг автоматжуулах зорилгоор E-Business системд хиймэл оюун ухаанд (AI) суурилсан нэр шалгах үйлчилгээг 2026.02.10-ны өдрөөс эхлэн нэвтрүүлсэн.</p> <p>Хиймэл оюунд суурилсан системийн хөгжүүлэлт хийгдсэнээр нэг талаас иргэн, хуулийн этгээдийн нэр баталгаажуулах процессыг хурдасгах ба нөгөө талаас улсын бүртгэгч хуулийн этгээдийн мэдээллийн санд нэрийн</p>	100

						давхцалыг шүүж, баталгаажуулах ажлыг хөнгөвчлөх давуу талтай болсон. Тайлант хугацаанд уг үйлчилгээнд нийт 192,003 хүсэлт ирснээс 148,680 хүсэлт буюу 77.4 хувь нь нэрийн давхардал болон ижил төстэй байдлын шалгуурт нийцээгүй тул татгалзсан хариу авсан бөгөөд 43,323 хүсэлт буюу 22.6 хувь нь шаардлага хангасан байна.	
2.3.	Нөөц дата төвд улсын бүртгэлийн байгууллагын мэдээллийн санг байршуулах.	Ухаалаг Засаг-2 төсөл хөтөлбөр	Байршуулсан мэдээллийн хувь	-	100	Бүртгэлийн нөөц дата төв байгуулах ажлын хүрээнд "Ухаалаг засаг-2" төслийн хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд: - "Саммит Компьютер Технологи" ХХК-тай 2025.11.28-ны өдөр SG-II/2.3.2.1 дугаартай бараа, үйлчилгээ нийлүүлэх гэрээ байгуулсан. - ЦХИХХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2026.01.09-ний өдрийн А/04 дүгээр тушаал болон дээрх гэрээний хэрэгжилтийн хүрээнд бүртгэлийн нөөц дата төвд шаардлагатай тоног төхөөрөмж, программ хангамжийн лицензийг хүлээн авах ажлыг зохион байгуулж, нийт 621 ширхэг тоног төхөөрөмж, лицензийг бүрэн хүлээн авсан. - Нөөц дата төвийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар Тагнуулын ерөнхий газраас зөвлөмж, чиглэл авах тухай 2026.04.07-ны өдрийн 1/2767 дугаар албан бичгийг хүргүүлсэн. - Суурилуулалт, тохиргооны ажлын хүрээнд серверийн өрөөний зохион байгуулалт, цахилгаан, сүлжээ, SAN болон	50

						<p>LAN сүлжээний кабелийн холболт, iDRAC IP хаягийн тохиргоо, хадгалалтын систем, SAN switch-ийн анхан шатны тохиргоо, firmware болон BIOS-ийн шалгалт зэрэг үндсэн ажлуудыг хийж гүйцэтгэн, виртуалчлалын орчны тохиргоо болон системийн анхан шатны туршилтуудыг амжилттай хэрэгжүүлж, тоног төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагааг баталгаажуулсан.</p> <ul style="list-style-type: none"> - Хуучин төхөөрөмжүүдийг нөөц дата төв рүү шилжүүлэх шийдвэр гарсантай холбоотойгоор шинэ төхөөрөмжүүдийг түр байрлалд байршуулан анхан шатны суурилуулалт, тохиргоо, виртуал орчны бэлтгэл болон өгөгдөл шилжүүлгийн бэлтгэл ажлыг гүйцэтгэсэн. - Дата нөөц төвийн rack дотор байрлах сүлжээний төхөөрөмж, сервер, сторэйж төхөөрөмжүүдийн зохион байгуулалт, загварчлал, сүлжээний топологи, SAN сүлжээний физик болон логик топологи, LAN сүлжээний физик болон логик топологийн зураглал, IP хаягийн хуваарилалтын төлөвлөлт, Dell R760 болон Dell R960 серверүүдэд VMware vSphere 8 платформыг суурилуулалтыг 2026.05.12-20-ны өдрүүдэд нийлүүлэгч байгууллага болох Саммит Компьютер Технологи
--	--	--	--	--	--	---

						ХХК-ийн инженерүүдтэй хамтран боловсруулж гүйцэтгэв.	
2.4.	Монгол Улсын иргэний хил нэвтрэх үнэмлэхийн бүртгэлийг хөтлөх техник тоног, төхөөрөмжийг нэмэгдүүлэх.	ADB	Нэмэгдүүлсэн тоног, төхөөрөмжийн тоо	5	10	Монгол Улсын иргэний хил нэвтрэх үнэмлэхийн бүртгэлийг хөтлөх техник тоног, төхөөрөмжийг Азийн хөгжлийн банкны хэрэгжүүлсэн төслийн хэрэгжилтээс хэмнэгдсэн төсөвт дүнгээр 2026.03.18-ны өдөр Саммит электроникс ХХК-аас Olivetti принтерийг 5 ширхгийг хүлээн авч, программ болон системийн тохиргоог хийж, нэгжүүдэд хүргүүлэхээр ажиллаж байна.	100
2.5.	Монгол Улсын иргэний хил нэвтрэх үнэмлэхийг хууль тогтоомжид нийцүүлэн (ИКАО) стандарт, шаардлагад нийцүүлэн MRZ хэрэглээнд нэвтрүүлэх санал боловсруулан эрх бүхий байгууллагад хүргүүлэх.	-	Санал хүргүүлсэн байгууллагын тоо	-	3	Засгийн газрын тогтоолыг хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд загвар байдлаар хэвлэсэн РР серийн паспортыг Хил хамгаалах ерөнхий газрын "Улсын хилээр нэвтэрч байгаа зорчигч, тээврийн хэрэгслийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан"-гийн систем, "Чингис хаан" олон улсын нисэх буудлын цахим гарцад шалгах ажлыг тус тус зохион байгуулж, 2026 оны 1/132 танилцуулах хуудсаар байгууллагын даргад танилцуулсан. Мөн үүнтэй холбоотой хийж хэрэгжүүлсэн ажлын танилцуулгыг бэлтгэж, шинэ сери бүхий энгийн гадаад паспортыг (хувийн РР ангилал) хэрэглээнд нэвтрүүлэхтэй холбогдуулан гарч болох эрсдэлийг харгалзан мэдээлэл хүргүүлж холбогдох арга хэмжээ авч өгөх тухай 2026 оны 1/2529 албан бичгийг Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлсэн.	80
2.6.	Архивын баримтыг хадгалах хамгаалах орчин нөхцөлийг сайжруулах.	Улсын төсөв	Хадгаламжийн сангийн агааржуулалтын системд засвар үйлчилгээ хийсэн тоо	-	1	Архив, үйлчилгээний цогцолбор төв байрны агааржуулалтын системийг 2026.02.03-ны өдөр "Хос цамхаг" ХХК-аар засвар, үйлчилгээ хийлгэж, хадгаламжийн сангийн агааржуулалтыг хэвийн үйл ажиллагаанд оруулсан.	100

						Хадгаламжийн сангийн чийг, дулааны хэмжээ стандартын дагуу хэвийн горимд ажиллаж байна.	
2.7.	Улсын бүртгэлийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох.	-	Боловсруулсан эрх зүйн актын төслийн тоо	-	2	Улсын бүртгэлийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд: - Засгийн газрын 2021 оны 226 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэвлэх журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулан, 2026.04.22-ны өдрийн 146 дугаар тогтоолоор холбогдох хэсэг, заалтад нэмэлт, өөрчлөлтийг оруулсан. - Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, түүнийг дагалдан гарах Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан.	100
			Эрх бүхий байгууллагад хүргүүлсэн саналын тоо	-	1	Улсын бүртгэлийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлын хүрээнд дараах саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлсэн. Үүнд: - Засгийн газрын 2021 оны 226 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл	100

						<p>хуудас хийлгэх, хэвлэх журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулан ХЗДХЯ-нд 2026.03.04-ний өдрийн 1/1948 дугаар албан бичгээр;</p> <p>- Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, түүнийг дагалдан гарах Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, ХЗДХЯ-нд 2026.06.03-ны өдрийн 1/4327 дугаар албан бичгээр тус тус хүргүүлэв.</p>	
2.8.	Улсын бүртгэлийн багц хуулийн хэрэгжилтэд үр дагаврын үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар хийлгэх.	Улсын төсөв	Үр дагаврын үнэлгээ хийлгэсэн тоо	-	1	<p>Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд тус тус хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг "Хууль зүйн үндэсний хүрээлэн"-ээр хийлгэж, судалгааны тайланг ХЗДХЯ-нд 2026.06.03-ны өдрийн 1/4327 дугаар албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Хууль зүй үндэсний хүрээлэнгийн 2026 оны 01/211 дугаар албан бичгээр ирүүлсэн Улсын бүртгэлийн ерөнхий хууль болон Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланд үндэслэн 2018 оны Улсын бүртгэлийн</p>	100

						багц хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналыг хуулийн төсөлд тусган ажиллав.	
2.9.	Улсын бүртгэлийн үйлчилгээний цахим машины (Киоск) тоог нэмэгдүүлэх.	Улсын төсөв	Нэмэгдүүлсэн цахим машины (Киоск) тоо	106	111	Улсын бүртгэлийн цахим үйлчилгээний киоскийг орон нутгийн таван салбар нэгжид үе шаттайгаар худалдан авч суурилуулах, холбогдох техникийн шаардлага, үзүүлэх үйлчилгээний төрлийг тодорхойлон, "Нью Компас" ХХК-тай гэрээ байгуулж, нийт 5 (таван) ширхэг киоск машиныг улсын төсвийн хөрөнгөөр худалдан авсан. Төхөөрөмжүүдийн программ хангамжийн суурилуулалт, анхан шатны тохиргоог хийж гүйцэтгэн, холбогдох бүртгэлийн мэдээллийн системүүдтэй уялдуулах ажлыг зохион байгуулж, ТӨБЗГ-ын тогтоолын дагуу хөрөнгийг Архангай, Хэнтий, Дорнод, Орхон аймаг болон Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэст бүртгэлжүүлэх ажлыг хууль, журмын дагуу шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.	100
ЗОРИЛТ 3. УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН СҮЛЖЭЭ, СҮЛЖЭЭНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАНА.							
3.1.	Улсын бүртгэлийн байгууллагын кибер аюулгүй байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, нэгдсэн сүлжээ, программ хангамж, системийн аюулгүй байдлыг хангаж, эрсдэлийг бууруулах.	Улсын төсөв	Кибер аюулгүй байдлын эрсдэлийн түвшин буурсан хувь	-	5	Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2026 оны А/38 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Улсын бүртгэлийн ерөнхий газрын үйл ажиллагаанд ашиглагддаг өгөгдлийн сан, мэдээллийн систем, сүлжээний бүтэц, зохион байгуулалтын талаар судалгаа, шинжилгээ хийх" удирдамжийн дагуу холбогдох судалгааг хийж, эрсдэлийг энэ оны зорилтот түвшнээс багагүй хувиар бууруулах боломжит ажил, арга хэмжээний санал боловсруулан, төлөвлөгөөг батлахаар ажиллаж байна. Улсын бүртгэлийн ерөнхий газрын УБЕГ/20260102006 дугаартай тендер шалгаруулалтын баримт бичгийг боловсруулж, 2026.02.13-ны өдөр	40

						<p>худалдан авах ажиллагааны цахим системээр (www.tender.gov.mn) тендер шалгаруулалтын зарыг байршуулах ажлыг зохион байгуулсан.</p> <p>Тус тендерийн Багц 1 “Тоног төхөөрөмж, лиценз худалдан авах” ажлын хүрээнд дараах тоног төхөөрөмж, лицензүүдийг хүлээн авсан.Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Албан хаагчдын компьютерт зориулсан антивирусын лиценз 375 ширхэг; - Dell EMC All Flash Unity 380F SSD 1 ширхэг; - Dell EMC Unity 880 HDD 2 ширхэг; - Dell EMC R740 SSD 1 ширхэг; - Гадна суурилуулах камер 3 ширхэг; - Сүлжээний кабель 8 ширхэг; - Телефоны кабель 3 ширхэг; - Сүлжээний толгой 35 ширхэг; - Телефоны толгой 5 ширхэг; - Багажийн ком 3 ширхэг; - Сүлжээний багажийн ком 3 ширхэг; - Суурин компьютер 5 ширхэг; - Өнгөт принтер 2 ширхэг; - Ажилтны үнэмлэх хэвлэх төхөөрөмж болон нэвтрэлтийн систем 1 ширхэг; - Ажилтны үнэмлэх хэвлэх карт 1,200 ширхэг; - Лифтний уншигчийн боард 3 ширхэг. <p>Кибер аюулгүй байдлын эрсдэлийн түвшинг 2 хувиар бууруулсан.</p>	
3.2.	Улсын бүртгэлийн нэгдсэн сангийн үйлдлийн систем, егөгдлийн санг лицензжүүлэх.	Улсын төсөв	Худалдан авсан лицензийн тоо	-	1	<p>Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллийн аюулгүй байдал, цахим үйлчилгээний тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах зорилгоор нийт 535 ширхэг программ хангамжийн лиценз худалдан авсан. Үүнд:</p>	100

						<ol style="list-style-type: none"> 1. Цахим гарын үсэг олгох үйл ажиллагааны тасралгүй байдлыг хангах зорилгоор “Тридум Э-Секьюрити” ХХК-тай 2026.02.09-ний өдөр Methics KIURU Mobile Signature Service Platform (MSSP) 1 сая хэрэглэгчийн тоон гарын үсгийн лицензийн сунгалтын үйлчилгээний гэрээг байгуулсан; 2. Бүртгэлийн нөөц дата төв байгуулах ажлын хүрээнд VMware vSphere Foundation 8 виртуалчлалын 160 лицензийг худалдан авч угсралтын ажлыг хийж гүйцэтгэсэн; 3. Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2026 оны Мэдээллийн технологийн үйлчилгээ худалдан авах тендерийн Багц-1 “Тоног төхөөрөмж, лиценз худалдан авах” ажлын хүрээнд “Саммит Компьютер Технологи” ХХК-тай 2026.03.23-ны өдөр 2026/10БГ–2026/12 дугаартай гэрээ байгуулж, албан хаагчдын компьютерын хамгаалалтад ашиглах антивирусын 375 лицензийг худалдан авч, хүлээн авах ажлыг зохион байгуулсан. 	
3.3.	Мэдээллийн аюулгүй байдалд аудит хийлгэх.	Улсын төсөв	Аудит хийлгэсэн тоо	-	1	Улсын бүртгэлийн ерөнхий газрын хэмжээнд мэдээллийн аюулгүй байдлын аудит хийлгэх тухай хүсэлтийг 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 1/935 дугаар албан бичгээр Тагнуулын ерөнхий газарт хүргүүлэн, тус газраас 2026.02.02-27-ны өдрийн хооронд аудит хийж, 2026.03.18-ны өдрийн н/... дугаар дүгнэлт ирүүлсний дагуу холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.	100

**ЗОРИЛТ 4.ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭН, ГАДААД ОРНЫ БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУРШЛАГААС БАЙГУУЛЛАГЫН
ОНЦЛОГТ ТОХИРУУЛАН ХЭРЭГЖҮҮЛНЭ.**

4.1.	Гадаадын болон олон улсын байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх.	Улсын төсөв, гадаадын зээл тусламж	Гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран зохион байгуулсан сургалтын тоо	6	7	<p>Тайлант хугацаанд гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран зохион байгуулсан 2 сургалтад 4 албан хаагч хамрагдсан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. БНХАУ-н ӨМӨЗО-ны Хөх хотод “Монголын хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны сургалт”-нд 2026 оны 05 дугаар сарын 12-ны өдрөөс 19-ны өдрүүдэд 3 албан хаагч; 2. Энэтхэгийн Техник, эдийн засгийн хамтын ажиллагааны (ITEC) хөтөлбөрийн 2026 оны нийт 11 сургалтын судалгааг хийж, хамрагдах хүсэлт ирүүлсэн албан хаагчдын анкет болон холбогдох материалыг Энэтхэгийн ЭСЯ-нд хүргүүлж 2026.06.08-19-ны өдрүүдэд 1 албан хаагч; <p>Мөн “Евроазийн иргэний бүртгэгчдийн нийгэмлэг”-ийн 2026 оны уулзалтыг Үндэсний статистикийн хороотой хамтран 2026.06.02-04-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулав. Уулзалтаар “Евроазийн орнуудын иргэний бүртгэлийн системийн өнөөгийн нөхцөл байдал”, “Улс орнуудын системийг сайжруулах чиглэлээр хийж буй ажлууд, ойрын төлөвлөгөө болон дараагийн алхмууд”, “Иргэний бүртгэгчдэд зориулсан өгөгдөл хамгаалалт ба өгөгдлийн засаглал” сэдвүүдээр танилцуулга, хэлэлцүүлгийг хийж, хөтөлбөрийн дагуу 2026.06.03-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газарт “Евроазийн иргэний бүртгэгчдийн нийгэмлэг”-ийн 29 зочид, төлөөлөгчдийг</p>	100
------	--	------------------------------------	--	---	---	---	-----

						хүлээн авч, танилцах айлчлалыг зохион байгуулан Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаа, иргэний улсын бүртгэлийн чиглэлээр хийж хэрэгжүүлж буй ажлыг танилцуулсан.	
ЗОРИЛТ 5.БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ НЭГДСЭН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТААР ХАНГАНА.							
5.1.	Бодлогын баримт бичиг болон захиргааны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.	-	Хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн тоо	12	20	<p>Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 тогтоолын журмын дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэхээр ажиллаж байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа 2050"-ын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг тайлант оны 10 дугаар 01-ний өдрийн дотор; 2. Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг тайлант оны 09 дүгээр 01-ний өдрийн дотор; 3. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Улсын хөгжлийн 2026 оны жилийн төлөвлөгөөний төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг тайлант оны 07 дугаар 01-ний өдрийн дотор дээд газарт хүргүүлэх талаар тусгасны дагуу эхний хагас жилийн байдлаар хяналт- шинжилгээ, үнэлгээ хийж, тогтоосон хугацаанд ХЗДХЯ-ны ХШДАГ-т хүргүүлэхээр бэлтгэж байна. <p>Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2026-2028 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг дахин боловсруулан, батлуулахаар Хууль зүй,</p>	100

						дотоод хэргийн яаманд 2026.03.27-ны өдрийн 1/2525 дугаар албан бичгээр хүргүүлсэн.	
			Хүргүүлсэн зөвлөмжийн тоо	2	4	Дээрх үнэлгээний мөрөөр газар, хэлтсүүдэд зөвлөмж хүргүүлнэ.	100
5.2.	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, төсвийн хөрөнгийг зүй зохистой зарцуулах, тайлагнах, байршуулах, санхүүгийн дотоод аудитыг хэрэгжүүлэх.	-	Дотоод аудит хийсэн нэгжийн тоо	4	6	Улсын бүртгэлийн ерөнхий газрын дотоод аудит, хяналт шалгалтын 2026 оны төлөвлөгөөг Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт шалгалт, дотоод аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 1/799 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д заасны дагуу тайлант хугацаанд Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаанд дараах дотоод аудит хийж гүйцэтгэсэн. Үүнд: - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн дотоод үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалтыг 2026.03.26-04.14-ний өдрүүдэд; - Дундговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дотоод үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалтыг хэлтэст 2026.06.02-05-ны өдрүүдэд; - Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дотоод үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалтыг хэлтэст 2026.06.06-09-ний өдрүүдэд хийж гүйцэтгэсэн. Дээрх нэгжүүдэд хийгдсэн төлөвлөгөөт шалгалтын дүнг УБЕГ-ын Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн.	100

			Хүргүүлсэн зөвлөмжийн тоо	4	6	Үнэлгээний мөрөөр холбогдох нэгжүүдэд зөвлөмж хүргүүлэн ажиллахаар бэлтгэж байна	30
5.3.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих.	-	Шилэн дансны хуулийг хэрэгжилтийн хувь	99.8	99.9	Шилэн дансны тухай хуульд заасны дагуу төсөв гүйцэтгэлийн 11 төрлийн мэдээлэл, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын 5 төрлийн мэдээлэл, бусад 7 төрлийн мэдээллийг Улсын бүртгэлийн 22 нэгж сар, хагас жил, жил, тухай бүр гэсэн хугацааны давтамжтайгаар холбогдох мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэт, цаг хугацаанд нь байршуулахад хяналт тавьж, I улирлын тайланг https://shilendans.gov.mn/ цахим системд хуулийн хугацаанд илгээсэн. Улсын бүртгэлийн байгууллага нь 2026 оны II улирлын байдлаар нийт тайлагнавал зохих 3 бүлэг 23 төрлийн 1689 удаагийн мэдээллийг нэгдсэн системд тайлагнахаас 21 мэдээллийг хугацаа хоцроож, 1668 мэдээллийг хуулийн хугацаандаа бүрэн байршуулсан ба гүйцэтгэл 98.76 хувь байна.	98.8
			Тайлагнаж, байршуулсан нэгжийн тоо	22	44	Улсын бүртгэлийн ерөнхий газар болон 21 аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нийт 22 нэгж сар бүр буюу 110 удаа тайлагнаж, байршуулсан байна.	100
5.4.	Улсын байгууллагын 2026 оны үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээ хийх.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	94	95	Байгууллагын эрсдэлийн удирдлагын төлөвшлийг батлагдсан үнэлгээний асуумжаар үнэлсэн өөрийн үнэлгээ, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө, эрсдэлийн удирдлагын 2026 оны төлөвлөгөөг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт 2026.02.02-ны өдрийн 1/1214 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. Төлөвлөгөөний хэрэгжилтийн 50 хувьтай.	100

						Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2026.02.16-ны өдрийн А/38 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу холбогдох судалгааг хийж, улсын бүртгэлийн байгууллагын кибер аюулгүй байдлын эрсдэлийг тодорхойлов.	
			Бууруулсан эрсдэлийн тоо	-	2	Эрсдэлийн үнэлгээг жилийн эцэст хийхээр төлөвлөн ажиллаж байна. Хугацаа болоогүй.	-
ЗОРИЛТ 6. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ХӨТӨЛБӨР, ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ САЛБАР ДУНДЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ДЭД ЗӨВЛӨЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛНЭ.							
6.1.	Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2026 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах.	-	Хэрэгжилтийг хангасан хувь	-	100	Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2026 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 зорилт, 8 арга хэмжээтэй төлөвлөн хэрэгжилтийг хангах хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, ил тод байдлыг хангах, цахим үйлчилгээг өргөжүүлэх чиглэлээр төлөвлөсөн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн. Авлигатай тэмцэх газраас бэлтгэн түгээсэн мэдээлэл, сурталчилгаа, авлигын мэдээллийг хүлээн авах 1-110 тусгай дугаарын талаарх мэдээллийг байгууллагын цахим хуудас, нэгжүүдийн цахим сувгаар дамжуулан олон нийтэд тогтмол хүргэж байна. Хууль тогтоомжид заасан нээлттэй мэдээлэл, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнгийн мэдээллийг тухай бүр цахим хуудсанд байршуулж, мэдээллийн ил тод байдлыг ханган ажилласан. Хууль зүй, дотоод хэргийн салбарын "Нээлттэй хаалганы өдөрлөг"-г оролцож, "АТГ Товч" аппликейшнийг сурталчлан таниулах, авлигын эсрэг мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх соён гэгээрүүлэх	100

						<p>үйл ажиллагааг зохион байгуулав. Мөн “Шүгэл үлээгч”, “Шударга ёсны дуу хоолой” уриалга бүхий постер, рийл болон “Хариуцлагатай төрийн албан хаагч байя” сэдэвт видео контентыг олон нийтэд түгээн ажилласан.</p> <p>Авлигатай тэмцэх газар, Нийслэлийн прокурорын газартай хамтран “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа” сэдэвт сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, төв болон орон нутгийн нийт 439 албан хаагчийг хамруулан авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдлэг, ур чадварыг дээшлүүлсэн. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд тулгуурлан үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээг дуусгавар болгох үйлчилгээг цахимжуулж, үйлчилгээний шат дамжлагыг бууруулан авлигын эрсдэлийг бууруулах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн.</p>	
6.2.	Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч, ашиг хүртэгчийн мэдээллийг нээлттэй мэдээллийг ил тод болгож, тогтмол шинэчлэх.	-	Нээлттэй мэдээллийн стандартаар ил тод болгосон хуулийн этгээдийн хувь	0	100	<p>“Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам”-ын 3 дугаар зүйлд заасан шаардлагын дагуу төрийн нээлттэй өгөгдлийн систем www.opendata.gov.mn/-д хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг Нээлттэй мэдээллийн стандартаар буюу JSON хэлбэрээр байршуулж, тухай бүр шинэчилж байна. Хуулийн этгээдийн нээлттэй мэдээллийг сайжруулж, холбогдох хөгжүүлэлтийг хийж, нийт 264,990 хуулийн этгээд буюу мэдээлэл 100 хувь нээлттэй мэдээллийн стандартаар ил тод харагдаж байна.</p>	100
6.3.	Аж ахуйн нэгж, байгууллагын эцсийн өмчлөгч, тусгай	-		33,515	50,000	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн санд аж ахуйн нэгж,	100

	зөвшөөрөл эзэмшигч, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн талаарх хүйсээр ангилсан мэдээллийн сангийн бүрдүүлэлт, баяжилтыг хийх.		Мэдээлэл сангийн бүрдүүлэлт, баяжилтын тоо			байгууллагын эцсийн өмчлөгч, тусгай зөвшөөрөл эзэмшигч, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн эцсийн өмчлөгч болон F регистртэй гадаадын хөрөнгө оруулагч, өмчлөгчдийн мэдээллийг бүртгэн хөтөлж байна. Тайлант хугацаанд нийт 65,332 хуулийн этгээдийн бүртгэлд эцсийн өмчлөгчийн мэдээлэл бүртгэгдсэн бөгөөд үүнээс эрэгтэй 192,375, эмэгтэй 132,096 иргэний мэдээлэл бүртгэгдээд байна. Энэхүү мэдээлэл нь хуулийн этгээдийн өмчлөл, эзэмшлийн бүтэц болон эцсийн өмчлөгчийн мэдээллийн ил тод байдлыг хангах, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд нэн шаардлагатай мэдээллийн сан юм.	
6.4.	Үйлчилгээний зааланд хөгжлийн бэрхшээлтэй иргэн үйлчлэх тэмдэг, тэмдэглэгээнд сонсголын бэрхшээлтэй иргэн гэх таних тэмдэг болон "Тусламжийн хонх"-ыг байршуулах.	Улсын төсөв	Таних тэмдгийг нэмж байршуулсан үйлчилгээний заалны тоо	-	49	Төлөвлөгөөний хэрэгжилтийг 1 дүгээр улиралд бүрэн ханган байгууллагын 52 (УБЕГ, 21 аймгийн УБХ, Нийслэлийн 30 нэгдсэн үйлчилгээний төв, цэгүүдэд) нэгжид "Тусламжийн хонх"-ыг бүрэн байршуулав. Тусламжийн хонхоор эхний хагас жилд нийт 67 иргэн үйлчлүүлсэн байна.	100
6.5.	Хөгжлийн бэрхшээлтэй болон тусгай хэрэгцээт иргэдэд зөөврийн тоног төхөөрөмжөөр явуулын үйлчилгээ үзүүлэх.	-	Үйлчилгээ үзүүлсэн иргэдийн тоо	154	300	Тайлант хугацаанд өөрийн биеэр үйлчилгээ авах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй болон тусгай хэрэгцээт 185 иргэнд 4G зөөврийн төхөөрөмжийг ашиглан (иргэний үнэмлэх шинээр болон дахин авах, үндэсний энгийн гадаад паспорт, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, тоон гарын үсэг, иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл, лавлагаа) гэрт нь (эмнэлэгт) очиж улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн.	100

ЗОРИЛТ 7. ЧАДАХУЙН ЗАРЧИМД СУУРИЛСАН ХҮНИЙ НӨӨЦИЙГ БҮРДҮҮЛЖ, АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАНА.

7.1.	Байгууллагын 2026 оны сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах.	-	Төлөвлөгөөний биелэлтийн хувь	86	92	<p>Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2026.05.04-ний өдрийн А/94 дүгээр тушаалаар "Улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах сургалтын хөтөлбөр (2026-2029)"-ийг баталсан. Хөтөлбөрийн хүрээнд байгууллагын 2026 оны сургалтын төлөвлөгөөг 3 зорилт, 56 арга хэмжээтэй баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд дараах сургалтыг зохион байгуулав. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Аймаг, дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн захиргааны ахлах мэргэжилтэн нарыг чадавхжуулах сургалтыг 2026.01.14-16-ны өдрүүдэд нийт 26 захиргааны ахлах мэргэжилтэн; - Шинээр томилогдсон албан хаагчдын чиглүүлэх сургалтыг 2026.03.02-10-ны өдрүүдэд зохион байгуулж 25 шинээр томилогдсон албан хаагч; - Удирдах ажилтны зөвлөгөөнийг 2026.03.12-14-ний өдрүүдэд зохион байгуулж 45 удирдах албан тушаалтан; - Байгууллагын дотоод нөөц бололцоог ашиглан танхимын 6 удаагийн сургалтад 145 албан хаагч; - Бусад байгууллагатай хамтран танхим болон цахим хосолсон 26 удаагийн сургалтад давхардсан тоогоор 1,370 албан хаагчийг тус тус хамруулсан. 	30
------	--	---	-------------------------------	----	----	---	----

7.2.	Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025-2028 онд хэрэгжүүлэх "Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах.	-	Төлөвлөгөөний биелэлтийн хувь	80	90	<p>Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025-2028 онд хэрэгжүүлэх "Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 зорилт 10 арга хэмжээтэйгээр 2026.03.20 өдөр батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Албан хаагчийн зэрэг дэвийн нэмэгдлийг шинэчлэн 119 албан хаагчид олгосноос 33 албан хаагчид шинээр, 86 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулсан байна. 2. Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу байгууллагын даргын тушаалаар 18 албан хаагчид 9,016,700 төгрөгийн тусламж, 29 албан хаагчид сургалтын цалинтай чөлөө, хөгжлийн бэрхшээлтэй албан хаагчид болон хөгжлийн бэрхшээлтэй, асаргаа шаардлагатай хүүхэдтэй 37 албан хаагчийн ажиллах цагийг 1 цагаар богиносгосон; 3. Аймаг, дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн 120 албан хаагч эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан; 4. Хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Улсын бүртгэлийн ерөнхий газрын албан хаагчдын дунд 2026 оны 02 дугаар сард гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулж, 05 дугаар сараас эхлэн иогийн сургалтыг 7 хоногийн 3 өдөр зохион байгуулж байна; 	100
------	---	---	-------------------------------	----	----	--	-----

						<p>5. Албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулан Азийн хөгжлийн банкны санхүүжилт, бусад төрийн байгууллагын дэмжлэгтэйгээр Төв аймаг, Налайх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн байранд нийт 8,100,000 төгрөгийн төсвөөр засвар үйлчилгээ хийсэн;</p> <p>6. Аймаг, дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэст шаардлагатай техник, тоног төхөөрөмж болох зөөврийн компьютер 30, суурин компьютер 30, принтер 23, скайнер 12 хүлээлгэн өгсөн;</p> <p>7. Архангай, Дорнод, Завхан, Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн албан хэрэгцээнд 4 автомашиныг тус тус хүлээлгэн өгөв.</p> <p>Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025-2028 онд хэрэгжүүлэх "Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн 70 хувь.</p>	
Биелэлтийн дундаж үнэлгээ						85.6	

---oOo---